

2019-2020 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛИЙН ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ДАДЛАГА ХИЙХЭД ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ

З.ТЭМҮҮЛЭН¹, Б.ЭНХТҮВШИН²

¹ДХИС – ийн Онцгой байдлын сургуулийн 641
дүгээр дамжааны сонсогч

²ДХИС-ийн Онцгой байдлын сургуулийн ГТТА тэнхимийн
дэд профессор, дэд хурандаа

Хураангуй

Жил бүрийн хичээлийн төгсгөлд “Онцгой байдал-гамшгаас хамгаалах алба” хичээлийн хөтөлбөрөөр суралцагч нар нь үйлдвэрлэлийн дадлагыг тодорхой тушаал, удирдамжийн дагуу хийж

гүйцэтгэдэг. Энэхүү дадлагын явцад олон амжилт болон тулгамждаж буй асуудлыг энэхүү өгүүллэгээр хүргэж байна.

Онцгой байдлын ерөнхий газрын дарга, Дотоод хэргийн их сургуулийн захирлын хамтарсан тушаал А/03-А/06 тушаал, удирдамжийн дагуу гал түймэр унтраах ажлын чиглэлээр 2020 оны 1 дүгээр сарын 13-ны өдрөөс 1 дүгээр сарын 31-ний өдөр 21 хоног, гамшгаас хамгаалах улсын хяналтын чиглэлээр 2 дугаар сарын 3 өдрөөс 2 дугаар сарын 21-ний өдөр 21 хоног, урьдчилан сэргийлэх, сургалт сурталчилгааны чиглэлээр 2 дугаар сарын 24-ний өдрөөс 3 дугаар сарын 20 өдөр 21 хоног, эрэн хайх, аврах ажиллагааны чиглэлээр 3 дугаар сарын 23-ны өдрөөс 04 дүгээр сарын 3-ны өдрийг дуустал 10 хоног нийт 3 сарын хугацаанд 2019-2020 оны хичээлийн жилийн үйлдвэрлэлийн дадлагыг амжилттай хийж дуусгалаа.

Судалгааны үр дүн

Дотоод хэргийн их сургуулийн Онцгой байдлын сургуулийн “Онцгой байдал-гамшгаас хамгаалах алба” хөтөлбөрөөр суралцах хугацаандаа 1 дүгээр дамжаанд Гал түймэр унтраах чиглэлээр 14 хоног, 2 дугаар дамжаанд Эрэн хайх, аврах чиглэлээр, 3 дугаар дамжаанд Гамшгаас хамгаалах чиглэлээр тус тус богино хугацааны дадлагыг хийж гүйцэтгэсэн. Харин энэ жилийн үйлдвэрлэлийн дадлагаар урьдчилан сэргийлэх, сургалт сурталчилгааны чиглэлээр дадлага хийсэн нь онолоор мэдсэн мэдлэгээ ашиглах боломж олгосон нэгдсэн цогц дадлага болж өнгөрлөө.

Гал түймэр унтраах чиглэлээр хийх хугацаанд гал түймэр унтраах, аврах ангийн үйл ажиллагаа, бүтэц зохион байгуулалттай танилцаж салааны захирагч өдөр тутмын үйл ажиллагаа, хэрхэн томилгоот ээлж халалцдаг ямар ямар бичиг баримт хөтөлдөг талаар танхимд үзэж байсан онолын мэдлэгийг бодитоор практикт ашигласан сонирхолтой дадлага болж өнгөрсөн (Зураг 1). Мөн Гал түймэр унтраах, Аврах 26 ангийн захирагч хошууч Адъяадорж дадлагын хугацаанд иж бүрэн гал унтраах байлдааны иж бүрэн хувцас хангаж өгсөн сонсогчдын эрүүл мэнд, хөдөлмөр хамгааллын дүрмийг сахин биелүүлэх боломж өгч дэмжлэг болсон нь талархал илэрхийлэх нь зүйтэй билээ.

Мөн Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй дүрэм, Гал түймэр унтраах дүрмийг хичээлийн хөтөлбөрт оруулж өгөх хэрэгтэй гэж бодож байна.

Зураг 2. Гамшгаас хамгаалах болон эрэн хайх аврах ажиллагааны чиглэлээр хийсэн үйлдвэрлэлийн дадлагын үеэр

Гамшгаас хамгаалах чиглэлээр гал түймрийн улсын хяналтын байцаагчийн хөтлөх бичиг баримттай танилцаж (зураг 2), гал түймрийн улсын хяналтын байцаагчийн мэдэгдэл, заавал биелүүлэх албан шаардлага, дүгнэлт зэргийн бичиж сурсан ба гамшиг ослын томоохон дуудлагаар гал түймрийн улсын хяналтын байцаагчтай дагалдан гал түймрийн хэргийн газарт анхан шатны үзлэгтэй хийх талаар туршлага олж авлаа. Сонгиохайрхан дүүргийн гал түймрийн 1-р улирлын бүртгэл хөтлөх хугацаанд судалгаагаар 2019 оны 1 дүгээр сар 2020 оны 1 дүгээр сартай харьцуулахад 6% -аар 2019 оны 2 дугаар сар 2020 оны 2 дугаар сартай харьцуулаад 17,9% - ээр буурсан үзүүлэлттэй байсан нь 2 дугаар сард COVID-19 вирус гарсантай холбоотойгоор иргэдийн хөл хөдөлгөөн багассантай холбоотой гэж тайлбарлаж болох юм. Гал түймэр өртсөн объектоос 2019 онд 45 хувь нь байшин харин 2020 онд 60 хувь нь байшин болж нэмэгдсэн үзүүлэлттэй байна. Өмчийн хэлбэрээр авч үзвэл 2019 онд 81 хувь нь хувийн 2020 онд 70 хувь нь хувийн өмч байсан дийлэнх нь хувийн сууц, байшин, гэр зонхилж байна.

Дүгнэлт

Цаашид дадлага хийх удирдамжид урьдчилан сэргийлэх, сургалт сурталчилгааны чиглэлээр, эрэн хайх, аврах ажиллагааны чиглэлээр хийгдэх ажлыг тусгаж өгөх, Гамшиг судлалын хүрээлэнд дадлага хийж байвал судалгаа шинжилгээний арга зүй, мэдлэгтэй болоход суралцагч нарт хэрэгтэй хэмээн үзэж байна.

Дадлагын удирдамжийн дагуу тухай газар хэлтэст дадлагыг дадлагажих ажилтны орон тоонд цалинтай хийвэл тухай дадлага хийж байгаа албан газар дадлагажигч сонсогчийг гэж үзэхээс илүү ажилтан талаас нь хандаж тухай дадлагажигч сонсогч нь мэдсэн сурсан онолын мэдлэгээ практик ашиглах боломж олгох бүрэн нээгдэх. Мөн дадлага хийх сонсогч нарын үнэлгээг тухай газар хэлтсийн тайлан мэдээнд нэмэгдэж байвал дадлага хийх сонсогч нарт илүү анхаарал хандуулах. Сайн дадлага хийсэн сонсогч нарыг шагнаж урамшуулж байвал илүү өрсөлдөөнтэй чанартай үйлдвэрлэлийн дадлага болно хэмээн үзэж байна.

Ашигласан материал, эх үүсвэрийн жагсаалт

1. Гамшгаас хамгаалах тухай хууль /шинэчилсэн найруулга 2017 оны 02 дугаар сарын 02-ны өдөр УИХ-аас баталсан/
2. Галын аюулгүй байдлын тухай хууль /шинэчилсэн найруулга 2015 оны 07 дугаар сарын 02-ны өдөр УИХ-аас баталсан/
3. Гал түймэр унтраах дүрэм, 2016 он